| | | | | | <p>тус тус бүртгэлтэй байна.</p> <p>УБЕГ-ын burtgel.gov.mn цахим хуудсанд байрлуулсан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн талаар гомдол гаргасан Төв аймгийн харьяа 17 иргэнтэй холбогдож гаргасан гомдлыг мэдээллийн санд шалгаж шийдвэрлэн иргэдэд хариу өгч, цаашид зөрчлийг арилгах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн. 2020 оны 01 дүгээр сарын 02-ноос 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдөр хүртэл тус хэлтэст ХААТР-25 маягтаар регистрийн дугаар өөрчилсөн сонгуулийн насны 11 иргэний мэдээллийг СНЖ-д шалгахад зөрчилгүй бүртгэгдсэн байсан.</p> <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “Иргэний шилжилт хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, энэ хуулийн 72.2-т заасны дагуу сонгуулийн дүнг нийтэд мэдээлсний дараах өдрөөс сэргээнэ” гэж заасны дагуу 2021 оны 01 сарын 02-ны өдрөөс 04 сарын 09-ний өдрийг хүртэлх хугацаанд Төв аймгийн 27 суманд бүртгэгдсэн нийт 702 шилжилт хөдөлгөөний бүртгэлийн журнал, нотлох баримт, ИУБ-22 маягтыг хүн тус бүрээр PDF файл хэлбэрээр хүлээн авч мэдээллийн санд шалгаж, бүрэн баталгаажуулж дууссан. Дээрх хугацаанд шилжилт хөдөлгөөний бүртгэлд насанд хүрсэн 702, хүүхэд 468 бүртгэгдсэнээс:</p> <ul style="list-style-type: none"> -Аймаг, нийслэлээс шилжин ирсэн насанд хүрсэн-368 Хүүхэд-220 -Сумаас суманд шилжин ирсэн насанд хүрсэн-87 -Хүүхэд-59 -Багаас багт, баг дотор шилжсэн насанд хүрсэн-247 -Хүүхэд-189 тус тус бүртгүүлсэн байна. <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн Төв аймгийн 17 дугаар тойргийн 98 хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг 2021 оны 05 сарын 13-ны өдрийн 08:30 цагаас 12:00 цаг хүртэл “ELECTION.GASR.MN програм”-аас хэсэг тус бүрийг 2 хувь хэвлэсэн. Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх явцад ямар нэг зөрчил гараагүй бөгөөд хэвлэх үйл ажиллагаанд аймгийн Тагнуулын хэлтсийн мэргэжилтэн Б.Эрдэнэ-Очир, н.Нямсүрэн, хэлтсийн дарга Н.Энхбат, хяналтын улсын байцаагч Б.Баярцэцэг нар хяналт тавьж ажилласан. Хэлтсээс 4</p> |
|--|--|--|--|--|---|

| | | | | | |
|--|--|--|--|--|---|
| | | | | | <p>баг гаргаж Сонгогчдын нэрийн жагсаалтыг Төв аймгийн 27 сумын сонгуулийн 98 хэсэгт 2021 оны 05 сарын 13-аас 14-ний хооронд акт үйлдэн хүлээлгэн өгсөн. Сонгогчдын нэрийн жагсаалт хүлээлгэн өгөх явцад зөрчил гараагүй.</p> <p>2021 оны 05 сарын 19-ны өдрөөс 27-ний хооронд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн Төв аймгийн 17 дугаар тойргийн 98 хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах 498 ширхэг лавлагааг “ELECTION.GASR.MN програм”-аас хэвлэсэн. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Сонгогч шилжин явсан-238 2. Сонгогч шилжин ирсэн-238 3. Нас барсан-21 4. Регистрийн дугаар өөрчилсөн-1 <p>2021.05.29-нд итгэмжлэгдсэн ажилтнуудын програмын сургалтын үеэр СНЖ-д өөрчлөлт оруулах лавлагааг тусгаж сонгогчдын нэрийн жагсаалтыг дахин 3% хэвлэж хэсгийн хороодод хүргүүлсэн.</p> <p>2021.06.09-ний өдөр буюу сонгуулийн өдөр Төв аймгийн 98 хэсгийн санал авах байранд сонгогчдын ирц бүртгэлийн үйл ажиллагааг Улаанбаатарын цагаар 07:00 цагаас 22:00 цаг хүртэл зохион байгуулж ажиллав. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн ирц бүртгэлийн мэдээг 98 хэсгийн хороодоос 11:00, 15:00, 22:00 цагуудад нэгтгэн авч УБЕГ-ын БТДШГ-т мэдээлсэн. Төв аймгийн 98 хэсгийн хороодын хэмжээнд санал өгөх ёстой нийт 62038 сонгогчдоос:</p> <ul style="list-style-type: none"> • Нийт санал өгсөн-33899 • “Түр хасав” төлөв сэргээсэн-13 • Зөөврийн битүүмжилсэн саналын хайрцагар саналаа өгсөн-909 • Хурууны хээгээр саналаа өгсөн-32742 • Регистрийн дугаараар бүртгүүлж саналаа өгсөн-235 сонгогч тус тус байна. <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын сонгох, сонгогдох эрхтэй холбоотой тус хэлтэст гаргасан өргөдөл, гомдол байхгүй.</p> |
|--|--|--|--|--|---|

| | | | | | | | |
|-----|---|---|---|--|---|---|-----|
| 3.2 | Улсын бүртгэлийн сар бүрийн тоон мэдээ, тайлан болон хийж хэрэгжүүлсэн томоохон ажлын тайланг харьяа дээд газарт хүргүүлэх | - | Заасан хугацааны дотор буюу дараа сарын 03-ны өдрийн дотор тайланг холбогдох газруудад хүргүүлсэн эсэх. | 2020 онд хугацаа хоцроосон мэдээ, тайлан байхгүй | Тайлан хугацаандаа УБЕГ-т болон аймгийн ЗДТГ-т хүргэгдсэн байна. | 2021 онд Улсын бүртгэлийн хэлтсээс сар бүрийн статистик, тоон мэдээг тухайн сарын 25-нд, тайлан болон хийж хэрэгжүүлсэн томоохон ажлын тайланг тухай сарын 20-ны дотор УБЕГГазар, аймгийн Засаг даргын Тамгын газар, статистикийн хэлтэст тухай бүр мэдээллэж ажилласан. | 100 |
| 3.3 | Улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцох, эрхийн улсын бүртгэлийг хаах мэдүүлэг бүхий нотлох баримтыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлэх | - | 1.Улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцох, эрхийн улсын бүртгэлийг хаах мэдүүлэг түүнд хавсаргасан нотлох баримтыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн тоо 2.Батлагдсан тушаалын дагуу холбогдох бүртгэл хийсэн эсэх | 2020 онд газар өмчлөх эрхийн үрэгдүүлсэн 56 гэрчилгээ, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн үрэгдүүлсэн 21 нийт 77 гэрчилгээг хүчингүйд тооцох болон эд хөрөнгийн эрхийн 7 улсын бүртгэлийг хаах мэдүүлэг бүхий нотлох баримтыг үндэслэн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалын төслийг боловсруулан ЭХЭУБГ-т хүргүүлж улсын ерөнхий бүртгэгчийн тушаалыг үндэслэн өмчлөгчид гэрчилгээг бичиж олгон, хувийн хэргийг хаах бүртгэл хийсэн. | Улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүйд тооцох, эрхийн улсын бүртгэлийг хаах мэдүүлэг бүхий нотлох баримтыг Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газарт хүргүүлж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын тушаалын хэрэгжүүлж ажилласан байна. | Газар өмчлөх эрхийн гэрчилгээ үрэгдүүлсэн 48, газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээ 11 нийт 59 гэрчилгээг хүчингүйд тооцуулах бүртгэл хяналтын байцаагчийн дүгнэлт гаргуулж, хувийн хэрэг хаалгах 4 хүсэлтийг нотлох баримтын хамт тус тус хүлээн авч ЭХЭУБүртгэлийн газарт явуулж ерөнхий бүртгэгчийн шийдвэр гаргуулж өмчлөгч нарт гэрчилгээг нөхөн олгож, хоёр хувийн хэргийг хаах бүртгэл хийсэн. | 100 |

ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.

| | | | | | | | |
|-------|--|---|---|---|--|--|-----|
| 4.5.1 | Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах | - | <p>1.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар батлуулсан эсэх,</p> <p>2.Гүйцэтгэлийн тайланг хугацаанд нь холбогдох газруудад хүргүүлсэн эсэх</p> | 2020 онд үр дүнгийн гэрээ 93.66%-тай дүгнэгдсэн. | Гүйцэтгэлийн төлөвлөгөө батлагдсан байх ба байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар гаргаж төв байгууллагад хүргүүлсэн байна. | Хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж 2021 оны 02 сарын 15-нд батлуулав, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг эрчимжүүлэн хагас жилээр болон III улиралд хэрэгжилт удаашралтай байгаа болон хугацаа болоогүй зарим арга хэмжээг дахин нягтлан тодотгож УБЕГазар болон, аймгийн ЗДТГазар ХШҮДАХэлтэст тайлагнан ажиллав. | 100 |
| 4.5.2 | “Хэлтсийн төрийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021”-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах | - | <p>1.Сургалтын төлөвлөгөө гаргасан эсэх</p> <p>2.Зохион байгуулсан сургалтын тоо</p> <p>3.Сургалтанд хамруулсан албан хаагчдын тоо</p> | УБЕГ-аас зохион байгуулсан 12 онлайн сургалт, хэлтсээс зохион байгуулсан 6 онлайн сургалт, танхимын 4 удаагийн сургалтанд хэлтсийн албан хаагчид, сумдын улсын бүртгэгчид болон улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнууд зэрэг давхардсан тоогоор нийт 606 албан хаагчдыг бүрэн хамруулав. | Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | <p>2021 онд Хэлтсийн даргын тушаалаар 4 зорилт 9 арга хэмжээтэй сургалтын төлөвлөгөө батлуулан ажиллаж байна, төлөвлөгөөний дагуу дотоодын сургалтаар сумдын улсын бүртгэгч нарт 2 удаа, Ерөнхийлөгчийн сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахтай холбогдуулан улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудад 1 удаа онлайн сургалт, 1 удаа танхимын буюу иргэний бүртгэлийн тоног төхөөрөмжийн сургалт, туршилт зохион байгуулж давхардсан тоогоор 398 төрийн албан хаагчид оролцсон 15 удаагийн цахим, 2 танхимын сургалтаар хууль, тогтоомж дүрэм журмыг танилцуулан сонгуулийн үеэр ажиллахад анхаарах асуудлуудаар заавар зөвлөгөө өгч ажиллав.</p> <p>Үүнд:</p> <p>1. 2021.01.22-ны өдөр “Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” цахим сургалт</p> <p>2. 2021 оны 03 сарын 31-ны өдөр “Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх , хүчингүй болгох, хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд” сэдэвт цахим сургалт</p> | 100 |

| | | | | | | |
|-------|---|---|---|---|--|-----|
| | | | | | <p>3. 2021.03.17 –ны өдөр “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхаарах асуудлууд” сэдэвт цахим сургалт</p> <p>4. 2021.0.4.20-ны өдөр “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ” цахим сургалт</p> <p>5. 2021.06.10-ны өдөр “ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл бүртгэх” тухай цахим сургалт</p> <p>6. 2021.06.22-ны өдөр “Иргэний улсын бүртгэлийн шинэ систем”-ийн цахим сургалт</p> <p>7. 2021.08.20-ны өдөр “Мэдээлэл технологийн инженерийн” нэгдсэн сургалт</p> <p>8. 2021.08.25-ны өдөр “Орон нутгийн улсын бүртгэгч нарыг чадавхижуулах” танхимын сургалт</p> <p>9. 2021.09.03-ны өдөр “Иргэний улсын бүртгэлийн улсын ахлах бүртгэгч нарт зориулсан” цахим сургалт</p> <p>10. 2021.03.22-ны өдөр сумдын улсын бүртгэгч нарт “Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас лавлаглаа олгох арга зүй” сургалт</p> <p>11. 2021 оны 02 сарын 16-ны өдөр хэлтсийн нийт албан хаагчдад “Ахисан түвшиний жендерийн дүн шинжилгээ ” сэдэвт цахим сургалт</p> | |
| 4.5.3 | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах | - | -Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо; | - | <p>2021.01.22-ны өдөр “Байгууллагын болон төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах арга зүй” цахим сургалт</p> <p>2021 оны 03 сарын 31-ны өдөр “Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх , хүчингүй болгох, хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавих, цуцлах бүртгэлд анхаарах асуудлууд” сэдэвт цахим сургалт</p> <p>2021.03.17 –ны өдөр “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн анхаарах асуудлууд” сэдэвт цахим сургалт</p> <p>2021.0.4.20-ны өдөр “Үр дүнд суурилсан бодлого төлөвлөлт, хяналт шинжилгээ үнэлгээ” цахим сургалт</p> <p>2021.06.10-ны өдөр “ Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн гэрээний бүртгэл бүртгэх” тухай цахим сургалт</p> <p>зэрэг хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулсан.</p> <p>1. 2021.05.10-ны өдөр УБЕГазраас “Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуульд Улсын бүртгэлийн байгууллагын хүлээх үүрэг, хариуцлага чиг үүрэг”</p> | 100 |

| | | | | | | | |
|-------|--|------------------------|---|---|---|---|----|
| | | | | | | <p>сэвэдт цахим сургалт</p> <p>2. 2021.05.12-ны өдөр сумдын улсын бүртгэгч, итгэмжлэгдсэн ажилтнуудад “Монгол улсын ерөнхийлөгчийн сонгууль” цахим сургалт хэлтсийн дарга Н.Энхбат, иргэний бүртгэлийн тасгийн дарга Д.Болормаа, хяналтын улсын байцаагч Б.Баярцэцэг нар</p> <p>3. 2021.05.29-ний өдөр “Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуульд итгэмжлэгдсэн ажилтнууд ажиллах техник тоног, төхөөрөмжтэй ажиллах, хууль эрх зүйн мэдлэг олгох” тухай тахимын сургалт УБЕгазрын иргэний бүртгэлийн ахлах бүртгэгч Наранцэцэг, мэдээлэл технологийн инженер, хэлтсийн сургалтын баг хамтран зохион байгуулсан байна.</p> | |
| 4.5.4 | 2021 онд иргэд, олон нийтэд улсын бүртгэлийн багц хууль, холбогдох журмуудыг хэрэгжүүлэх талаар танилцуулга хийж, сургалт зохион байгуулах | Улс орон нутгийн төсөв | <p>1.Зохион байгуулсан сургалтын тоо</p> <p>2.Сургалтанд хамруулсан иргэдийн тоо</p> <p>3.Видео танилцуулга шторк хийсэн эсэх</p> | - | <p>Сургалт зохион байгуулж иргэдийн оролцоо идвэхийг өрнүүлсэн, улсын бүртгэлийн үйлчилгээтэй холбогдолтой хуулийн мэдлэг дээшилж зохих мэдээллийг авсан байна.</p> | <p>Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Төв аймгийн 27 сумын 98 хэсгийн хороодод ажиллах 98 итгэмжлэгдсэн ажилтнуудад зориулсан эрх зүйн онлайн сургалтыг 2021 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 10:00-12:30 цагийн хооронд цахим хэлбэрээр зохион байгууллаа. Сургалтанд батлагдсан хөтөлбөрийн хүрээнд “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль”, “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, танилцуулах журам”, “Сонгуулийн үйл ажиллагаанд анхаарах асуудал” сэдвээр итгэмжлэгдсэн ажилтнуудад хичээл зааж, сургалтын төгсгөлд итгэмжлэгдсэн ажилтнуудын асуултанд хариулж, сонгогч шилжих талаар тодорхой зөвлөгөө мэдээлэл өглөө.</p> <p>Мөн Улсын бүртгэлийн ерөнхий газраас баталсан удирдамжийн дагуу “Улсын бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтнуудын дунд зохион байгуулагдах сонгогчийн ирц бүртгэлийн программын сургалтын үед хийгдэх үйл ажиллагааны нэгдсэн удирдамж”, Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн даргын баталсан хөтөлбөрийн хүрээнд аймгийн ЗДТГ-ын хурлын танхим, Соёмбо танхим, Татварын хэлтсийн сургалтын заал, Зуунмод сумын ЗДТГ-ын хурлын танхим зэрэг 4 байршилд Төв аймгийн 27 сумын 98 хэсгийн 98 итгэмжлэгдсэн ажилтан нарыг хамруулан програмын сургалтыг 2021</p> | 70 |

| | | | | | | | |
|-------|---|---|---|---|---|--|-----|
| | | | | | | оны 5 дугаар сарын 29-ны өдөр Төв аймгийн Зуунмод суманд зохион байгуулав. Эрх зүйн сургалтын дараа сургалтын баг, хэлтсийн шуурхай баг, аймгийн Тагнуулын хэлтсийн мэргэжилтэн нарын хяналтанд сонгогчийн ирц бүртгэлийн тоног төхөөрөмжийн цүнхийг онгойлгож итгэмжлэгдсэн ажилтнуудаар ирц бүртгэлийн програмыг асаах, сонгогчийн ирц бүртгэлийг нээж ажиллуулах, сонгогчийн хувийн мэдээллийг нягтлан шалгах, ирцийн мэдээ хэвлэх, сонгогчийн бүртгэлийн хуудас хэвлэх зэрэг дадлага хийлгэсэн. Сургалт, дадлагаж ажлын төгсгөлд Мэдээллийн технологийн ажилтан нар итгэмжлэгдсэн ажилтан сонгуулийн санал авах өдөр ажиллах ирц бүртгэлийн компьютерт цаг, бүртгэлийн хуудас хэвлэх төхөөрөмжийг таниулан шалгасны дараа ирц бүртгэлийн программыг түгжин, холбогдох кодыг хүлээлгэн өгч, тэмдэглэл үйлдэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан. | |
| 4.5.5 | Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны мэдээллийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн 11 дүгээр сарын хуралд тайлагнах | - | Аймгийн Засаг даргын зөвлөлд тайлан мэдээлэл хэлэлцүүлснээр | Жил бүр хэлтсийн үйл ажиллагааны мэдээлэл, тайланг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулдаг. | Аймгийн нутгийн захиргааны байгууллага хоорондын ажлын уялдаа холбоо хангагдсан байна. | Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны 10 сарын 11-ны өдрийн А/647 дугаартай бодлого, төлөвлөгөөний баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, гүйцэтгэлийг сайжруулах тухай үүрэг болгосон тушаалыг хэрэгжүүлэн хэлтсийн даргын Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт удаашралтай, хугацаа болоогүй зарим арга хэмжээг нягтлан тодотгож улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны үйл ажиллагааны мэдээллийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд тайлагнах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 70 |
| 4.5.6 | Улсын бүртгэлийн хэлтсийн нийт төрийн албан хаагчид авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байж, ХАСХОМ /хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг/-ыг хуулийн хугацаанд | - | ХАСХОМ-ыг Хуулийн хугацаанд мэдүүлсэн төрийн албан хаагчдын тоогоор | 2020 онд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогоо мэдүүлэх нийт 39 төрийн албан хаагч хуулийн хугацаанд бүгд мэдүүлсэн | Хуулийн хугацаанд буюу 2022 оны 02 сарын 15-аас өмнө нийт төрийн албан хаагч бүгд үнэн зөв мэдүүлсэн байна. | Төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, албан тушаалтнуудын хөрөнгө орлого, ашиг сонирхлын мэдүүлгийг хүлээн авч гарын үсэг зуруулан нэгтгэсэн бөгөөд шинэчилсэн 37, шинээр томилогдсон 7, их хэмжээний өөрчлөлт оруулсан 1 албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч хуулийн хугацаанд мэдүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|--|---|---|--|--|--|---|-----|
| | мэдүүлнэ. | | | | | | |
| 4.5.7 | Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллана | - | -Төлөвлөгөө гарсан эсэх -Хэрэгжилтийг ханган ажилласан байдал | - | Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах аймгийн зөвлөлийн ажилтай уялдуулан төлөвлөгөө боловсруулан гаргаж, хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг 2 зорилт 4 арга хэмжээтэй батлан гаргаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021 оны 05 сарын 12-ны өдөр “Монгол улсын ерөнхийлөгчийн сонгуульд ажиллах итгэмжлэгдсэн ажилтнуудад тагнуулын хэлтэстэй хамтарсан “Төрийн олон албаны нууцыг хамгаалх нь” сэдэвт онлайн сургалт, мөн оны 05.29-ний өдөр итгэмжлэгдсэн ажилтангуудын техник тоног, төхөөрөмжийн сургалт зохион байгуулж сумдад ирц бүртгэлийн тоног, төхөөрөмж хүлээлгэн өгөх ажилд аймгийн Тагнуулын хэлтэстэй хамтран хяналт тавин, гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлж ажилласан. Мөн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж аймгийн Цагдаагийн газартай хамтран “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль” зэрэг сэдвээр цахим сургалтууд зохион байгуулж 27 сумын улсын бүртгэгч, сумдын иргэдийн төлөөлөл оролцож нийт 3 удаагийн сургалтаар давхардсан тоогоор 120 орчим хүн хамрагдав. | 100 |
| Зорилт 6. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 4.6.1 | Иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн улсын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг шийдвэрлэх | - | Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувиар | 2020 онд тус хэлтэст нийт 107 өргөдөл гомдол бүртгэгдсэнийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй. | Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна. | 2021 оны эхний хагас жилд тус хэлтэст нийт 20 өргөдөл гомдол бүртгэгдсэнийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдол шийдвэрлэлтийн улирал тутмын мэдээг УБЕГ болон аймгийн ЗДТГазарт тухай бүр хүргүүлж ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|-------|---|---|---|---|---|---|-----|
| 4.6.2 | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих | - | 1.Баримт бичгийн эргэлтийн тоогоор 2.Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувиар | 2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 1025 бичиг ирсэн ба 1222 албан бичиг явуулсныг бүртгэж бүртгэл хөтлөн, ДУС-ын албан бичгийн бүртгэлд бүртгэн дугаарлаж хяналтын карт хэвлэсэн. Нийт ирсэн бичгээс 659 хугацаатай, хариутай бичиг байсан. | Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна. | 2021 оны эхний хагас жилийн байдлаар тус хэлтэст нийт бичиг 873 ирсэн ба 1080 албан бичиг явуулсныг бүртгэж бүртгэл хөтлөн, ДУС-ын албан бичгийн бүртгэлд бүртгэн дугаарлаж хяналтын карт хэвлэсэн. Нийт ирсэн бичгээс 605 хугацаатай, хариутай бичиг байсныг хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлсэн. | 100 |
| 4.6.3 | Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих | - | Үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмыг хэрэгжүүлсэн байна | - | Үйл ажиллагаандаа мөрдөж, стандартын зөрчил гараагүй байна. | УБЕГазрын даргын 2019 оны А/685 дугаар тушаалаар баталсан “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандарт”, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, байгууллагын дотоод журмыг мөрдөн хяналт тавин ажиллаж байна. Зөрчил гаргасан 1 албан хаагч /Сүмбэр сум, Г.Бямбасүрэн/-д УБЕГазрын Ёс зүйн зөвлөлөөс сахилгын шийтгэл ногдуулсан. | 100 |

| | | | | | | | |
|-------|---|---|---|--|--|--|-----|
| 4.6.4 | Хэлтсийн дотоод архив албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу эрхлэн явуулж, удирдлагаас өгсөн үүрэг, гарсан тушаал шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллах | - | Хурлын тэмдэглэл, удирдлагаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилт, Тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх. Холбогдох хууль тогтоомжийн дагуу тушаал, шийдвэрийн төсөл боловсруулсан эсэх. Архивт хүлээн авсан баримтын тоогоор | 2020 онд 9 удаагийн даргын зөвлөлийн шуурхай хуралдаж 10 үүрэг даалгавар өгөгдсөн. 2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын /А/ тушаал 25 батлагдан ирсэн. -2019 оны жилийн эцсийн байдлаар хэлтсийн даргын А-28, Б-25 нийт 53 тушаалыг боловсруулж, эцэслэн гаргасан. | Тушаал шийдвэрийн бүртгэлийг сар, өдрийн дарааллаар нарийн хөтөлж шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Архивын хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажилласан байна. | 2021 оны III улирлын байдлаар 12 удаагийн даргын зөвлөлийн шуурхай хуралдаж 17 үүрэг даалгавар өгөгдсөн. 2021 оны III улирлын байдлаар тус хэлтэст УБЕГ-ын даргын /А/ тушаал 14, /Б/ тушаал 16 батлагдан ирсэн. -2021 оны хагас жилийн байдлаар хэлтсийн даргын А-12, Б-5 нийт 17 тушаалыг боловсруулж, эцэслэн гаргасан ба тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. | 100 |
| 4.6.5 | Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах | - | Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх. | 2019,2020 онд Төрийн болон албаны нууцтай холбоотой иргэний лавлагаа авах 2 хариутай албан бичиг ирсэн ба хариуг хүргүүлж ажилласан. Тус хэлтэст нууцтай холбоотой нийт ирсэн бичиг 8, явуулсан бичиг 4 хадгалагдаж байна. | Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. | Төрийн болон албаны нууцтай холбоотой хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 оны 3-р улирлын байдлаар иргэн хуулийн этгээд болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн төрийн болон албаны нууцтай холбоотой албан бичиг тоот шүүхийн шийдвэр, тагнуулын байгууллагын хүсэлт ирээгүй болно. Хуульзүй дотоод хэргийн яамны сайдын 2021.02.24-ны өдрийн А/28 тушаалаар батлагдсан нууцад хамаарах баримт бичгийн жагсаалт батлах тушаалын дагуу Тагнуулын ерөнхий газрын Төв аймаг дахь хэлтсээс тус хэлтсийн нууцад хамаарах баримт бичгийн хадгалалт, хамгаалалтанд хяналт шалгалт хийсэн. Уг шалгалтын дагуу ирүүлсэн албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилтийг хэлтсийн 2021.03.16-ний №289 тоот албан бичгээр хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|-------|--|---|---|--|---|---|-----|
| 4.6.6 | Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх | - | Сар бүр иргэд, аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн боршруу хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоогоор | 2020 онд бүртгэлийн үйлчилгээний сар бүрийн статистик тоон мэдээ, хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээгээр 50 гаруй инфографик бэлтгэн хэлтсийн http://burtgel.to.gov.mn/ веб хуудас, “Төв аймаг Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд байршуулан олон нийтэд хүргэлээ. | 12 сарын байдлаар үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээлэл иргэдэд хүрсэн байна. | 2021 оны тайлант хугацаанд бүртгэлийн үйлчилгээний сар бүрийн статистик тоон мэдээ, хэлтэст ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээгээр 80 гаруй инфографик бэлтгэн хэлтсийн http://tuv.burtgel.gov.mn/ веб хуудас, “Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд байршуулан олон нийтэд хүргэв. | 100 |
| 4.6.7 | Улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг шинэчлэх чиглэлээр аливаа төсөл боловсруулахад хэлтсээс тухай бүр санал хүргүүлнэ | - | Улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг шинэчлэх төсөлд хүргүүлсэн саналын тоогоор | 2020 онд иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, Сонгуулийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах төсөлд тус хэлтсээс саналаа хүргүүлсэн. | Улсын бүртгэлийн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг шинэчлэх төсөлд санал хүргүүлж, тусгасан байна. | Хуулийн этгээдийн бүртгэлийн нэгдсэн систем, ERS прогаммыг шинэчлэх өдөр тутамын бүртгэлд гарч буй хүндрэл, алдаатай байгаа хэсэг дээр засвар шинэчлэлтийн санал авах ажлыг 21 аймаг, 3 дүүргийн хуулийн этгээдийн улсын бүртгэгч нараас цахим хандалтаар авсан. Зарим сайжруулах шаардлагатай гэсэн санал, гарч буй алдааны талаар тухай бүр хүргүүлж ажиллав. | 100 |
| 4.6.8 | Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох | - | Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагыг төлөөлөн оролцсон эсэх | 2020 онд Сум дундын Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд 1 нэхэмжлэл ирсэн боловч шүүхээр хэлэлцээгүй байна. | Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцож, байгууллагын эрх ашгийг хамгаалсан байна. | 2021 оны III улирлын байдлаар иргэн, хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой хууль шүүхийн байгууллагад нэхэмжлэлтэй хэрэг, маргаан гараагүй. | 100 |

| | | | | | | | |
|-------|---|-------------------------|---|--|---|--|-----|
| 4.6.9 | Байгууллагын үйл ажиллагааг цахим болон пэйж хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох | Улс, орон нутгийн төсөв | 1.Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулсан тоо 2.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоогоор | 2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг “Төв аймаг Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудас, http://burtgel.to.gov.mn/ сайтанд байршуулж нийт 604 мэдээ, пост оруулсан. | Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна | <p>Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх, олон нийтийн оролцоог хангах зорилгоор олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.</p> <p>Тайлант хугацаанд: “Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудас нь 2274 like, 2373 дагагчтай байгаа бол http://tuv.burtgel.gov.mn/ веб хуудас нь нийт 6955 хэрэглэгчдийн хандалт авсан байна.</p> <p>http://tuv.burtgel.gov.mn/ веб хуудсанд нийт 546 мэдээ мэдээллийг нийтэлсэн.</p> <ul style="list-style-type: none"> ○ Санхүүгийн ил тод байдлын талаар 20 ○ Хурал, сургалт, семинар, хэлэлцүүлгийн талаар 13 ○ Жил, улирлын тайлан 3 ○ Нээлттэй ажлын байрны зар 2 ○ Өргөдөл, гомдол шийдвэрлэсэн байдалаар 21 ○ Сар бүрийн статистик тоон мэдээ 21 ○ Түгээмэл асуулт хариулт 25 ○ Цаг үеийн мэдээ /хэлтэс, орон нутагтай холбоотой мэдээ тэмээлэл/ 237 ○ Видео мэдээ /хэлтэс, орон нутагтай холбоотой мэдээ тэмээлэл/ 73 ○ Топ мэдээ 19 <p>“Төв аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс” Фэйсбук хуудсанд нийт шторк, хэвлэн олшруулж байршуулах материал, инфографик зэргээр нийт 429 мэдээ мэдээллийг нийтэлсэн. Мөн хэлтсийн үйлчилгээний заалны дэлгэцэнд Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой шторк мэдээллийг 23 удаагийн /өдөр бүр/ давтамжтайгаар байршуулсан ажилласан.</p> | 100 |
|-------|---|-------------------------|---|--|---|--|-----|

| | | | | | | | |
|--|--|-------------|---|--|---|---|-----|
| 4.6.10 | Сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах замаар иргэний улсын бүртгэлийн хууль, тогтоомжийг сурталчилж, иргэдийг мэдээ, мэдээллээр хангах | Улсын төсөв | Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулсан тоо, мэдээлэл хүргэсэн иргэдийн тоо | 2020 онд 8 суманд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Улсын бүртгэлийн багц хууль, дагалдан гарсан журмууд, зөрчлийн тухай хуулиар 720 гаруй иргэдэд танилцуулга, мэдээлэл хүргэсэн. | 8 суманд Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж 700 доошгүй иргэдэд мэдээлэл хүргэсэн байна. | Ковид19 халдварын улмаас бүх нийтийн хатуу хөл хорио тогтоож олон нийтийг хамарсан аливаа арга хэмжээг хориглосонтой холбоотой сумдад нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж иргэдэд мэдээлэл хүргэх ажил хойшлогдож ирсэн. 2021 оны IV улиралд багтаан хийгдээгүй байгаа төлөвлөгөөт ажлаа шахан хийж гүйцэтгэхээр 8 суманд ажиллах хуваарь гарган ажиллаж байна. | - |
| Зорилт 7. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай монгол улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана. | | | | | | | |
| 4.7.1 | Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах | | Санал тавьж шийдвэрлүүлсэн н эсэх; | | Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна. | Хэлтсийн дарга аймгийн сонгуулийн хорооны бүрэлдэхүүнд орж ажиллав. Аймгийн ИТХ, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, орон нутгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн төрийн байгууллагуудтай уялдаа холбоотой хамтран ажиллаж ирсэн. Мөн архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах, шаардлагатай тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхээр зохих судалгааг гаргаж 2021 оны 05 сарын 18-ны 524 тоот албан бичгээр аймгийн Засаг дарга, Төрийн архивын тасагт санал хүргүүлэн шийдвэрлүүлэхээр ажиллаж байна. | 100 |
| Зорилт 8. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ. | | | | | | | |
| 4.8.1 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах | Улсын төсөв | Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх | 2020 оны 11 сарын 30-ны байдлаар 604,665,900 төгрөгийн санхүүжилт авч 594,110,156.51 төгрөгийн зарцуулалт хийж 10,555,743,49 төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж байна. Өглөг, авлага | Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна. | Тус хэлтэс 2021 оны 9 сарын 30-ны байдлаар 497.021,4 мян төгрөгийн санхүүжилт авч 487.507,6 мян төгрөгийн зарцуулалт хийж 9513,7 мян төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан. 2020 оны санхүүгийн тайланд аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлт авсан. Зөвлөмжийн хариуг заасан хугацаанд явуулсан. 2021 оны 7 сард УБЕГазар, Санхүү төлөвлөлтийн хэлтэст 2022 оны төсвийн төслийг нийт 832.697.900 2022 төгрөгөөр төсөөлж санал хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|-------|--|---|---|--|--|---|-----|
| | | | | байхгүй. 2020 оны тайланг үдэж архивын нэгж үүсгэсэн. Asolous болон цалингийн программыг бүрэн ашиглаж байна. Мөн 2013-2019 онуудад санхүүгийн тайлангийн аудитаар зөрчилгүй санал дүгнэлт авсан. | | | |
| 4.8.2 | Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг сайжруулах, улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах | - | -Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх, -үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх, -байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх. | 2020 оны тооллогоор 5577.3 мян төгрөгийн бичиг хэрэг, 22800.6 мян төгрөгийн бусад материал, 24040.2 мян төгрөгийн үнэт цаас, 1,112,590.8 мян төгрөгийн үндсэн хөрөнгийг нүд үзэн тоолсон. Тооллогын явцад дутагдсан үрэгдсэн хөрөнгө гараагүй. | Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн байна. | 2020 оны жилийн эцсийн тооллогын комиссын 17681722.06 мөнгөний 12 нэр төрлийн 18 ширхэг хөрөнгө актлах саналыг Өмч хамгаалах зөвлөл хэлэлцэн 3 сарын 29-нд УБЕГазарт хүргүүлсэн болно. Өмч хамгаалах зөвлөл нь 2010 онд сумдад хувиарласан шинэчилсэн бүртгэлийн тоног төхөөрөмж болох 138.769,0 мянган төгрөгийн 6 нэр төрлийн 132 ширхэг хөрөнгө актлах санал хүргүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|-------|---|-------------|---|--|--|---|-----|
| 4.8.3 | Байгууллагын хэвийн үйл ажиллагааг болон дараа жилийн зорилтыг хангахуйц төсвийг төлөвлөх, хүргүүлэх, батлуулах | Улсын төсөв | Санхүүгийн үйл ажиллагааг хэвийн, тасралтгүй явуулах нөхцлөөр бүрэн хангахуйц 2021 оны хөрөнгө оруулалтын болон урсгал зардлын төсвийн төслийг УБЕГ-ын СТХ-т хүргүүлсэн байна | 2020 оны 11 сарын 30-ны байдлаар 604,665,900 төгрөгийн санхүүжилт авч 594,110,156.51 төгрөгийн зарцуулалт хийж 10,555,743,49 төгрөгийн үлдэгдэлтэй ажиллаж байна. | 2021 онд байгууллагын үйл ажиллагааг хэвийн, найдвартай, тасралтгүй явуулахад хүрэлцэхүйц төсөвлөсөн төслийн саналыг УБЕГ-т Төсвийн тухай хуульд заасны дагуу хугацаанд нь хүргүүлсэн байна. | 2021 онд нийт 497.021.400 төгрөгийн санхүүжилт авч 2021 оны 09 сарын 30-ны байдлаар 487.507.672 төгрөгийн зарцуулалт хийж, 9.513.727 төгрөгийн үлдэгдэлтэй, санхүү, нягтлан бодох бүртгэлийн алдаа дутагдалгүй ажиллав. 2021 оны 7 сард УБЕГГазар, Санхүү төлөвлөлтийн хэлтэст 2022 оны төсвийн төслийг нийт 832.697.900 2022 төгрөгөөр төсөөлж санал хүргүүлсэн. | 100 |
| 4.8.4 | Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах | - | Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоогоор | 2020 оны 12 сарын 25-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 122 мэдээлэл оруулахаас 122-ийг хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна. | 9 сарын 30-ны байдлаар 109 мэдээлэл бүрэн оруулж 100 хувь шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан. | 100 |